

| May 2023



# Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ажуул тухай

ХУУЛЬЧ М.ҮҮРИЙНТУЯА

## Үйл баримт

Х.Т- нь 2018 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр 25-47 00- улсын дугаартай хийн дугуйт индүүдэгч машины операторчоор ажиллаж, Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо, Я-ийн гүүрний зам дээр дэвссэн асфальт бетоныг нягтаршуулах ажлын индүүдэгч машины операторын үүргийг гүйцэтгэсэн. Операторын үүргийг гүйцэтгэж байх үедээ буюу ухрах үйлдэл хийх үед ухрах зам талбайд хүн, саад байгаа эсэхийг анхаарч хараагүйн улмаас Ц.Б-ыг дайрсан.

## Хохирол, хор уршиг

Ц.Б-ын биед нь “Хоёр талын олон хавирганы хугарал, уушгины эдийн няцрал, цус хуралт, зүүн шууны ясны далд хугарал, бугуйн үений мултрал, баруун доод чөмгийн далд хугарал зэрэг гэмтэл учирсан бөгөөд эмнэлгийн тусламж, үйлчилгээ авч байх үедээ нас барсан.

## Шүүгдэгчийн биеийн байцаалт

33 настай, эрэгтэй, жолооч мэргэжилтэй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл 4, эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг. Үүнээс гадна Х.Т нь индүүдэгч машины операторын мэргэжлийн үнэмлэхгүй байсан.

## Туршилт

Мөрдөн шалгах туршилт хийсэн тэмдэглэлд дурдсанаар “ Индүүдэгч машины ар талд 170 см өндөртэй эрэгтэй хүнийг 2 метрийн зайд зогсоож индүүдэгчийн операторч харах боломжтой эсэхийг харьцуулж үзэхэд зогсож буй хүнийг цээжнээс дээш харах боломжтой байв” гэсэн.

## Бусад нөхцөл байдал

Х.Т- нь хохирогчийн хууль ёсны төлөөлөгч буюу Ц.Б-ын эхнэр Б.Б-т амь хохирогчийг оршуулахтай холбоотой зардалд нийт 11.000.000 төгрөгийг нөхөн төлсөн.



Та энэ тохиолдлыг хэрхэн  
дүгнэж байна вэ?

## Монгол Улсын Үндсэн хууль

Арванзургадугаар зүйлийн 1-ийн 4-т “..Иргэн нь хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрхтэй..”

## Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль

18 дугаар зүйлийн 18.2.1 дэх "Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлага, стандарт, дүрэм, технологийн горим чанд мөрдөх";

18 дугаар зүйлийн 18.2.7-д ажилтан “өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх” үүргээ биелүүлээгүй ;

28 дугаар зүйлийн 28.1.8-д ажил олгогч нь “аюулгүй ажиллагааны мэдлэг олгох сургалт явуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэгийг жил бүр шалгах, аюулгүй ажиллагааны зааварчилга өгөх, сургалтад хамрагдаагүй, зааварчилга аваагүй, шалгалт өгөөгүй ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлэхгүй байх” үүрэгтэй

## Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дүрэм

9 дүгээр зүйлийн 9.1-ийн 3 дахь хэсэг "ажлыг аюулгүй арга барилаар гүйцэтгэхэд суралцаж, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа авч ажлын байранд дадлагажиж, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэгээ шалгуулж, бие дааж ажиллах зөвшөөрөл авсан байна.

9.1.4 дэх "Автомашины эд анги дээр суурилагдаагүй замын машиныг эдгээр машиныг ажиллуулах эрх бүхий хүн ажиллуулна

9.1.8 дахь "...үйлдвэрлэлийн талбай буюу ажлын байранд гаднын зөвшөөрөлгүй этгээд, согтуу хүн оруулахыг хориглоно" заалтуудыг зөрчсөн байна..."

9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх "/Удирдаж буй хүн /инженер болон механик инженер/-д ажлыг аюулгүй гүйцэтгэх талаарх мэдлэгээ шалгуулж, үүрэг даалгавар авах бөгөөд ээлж хүлээлцэх бүртгэл хөтөлж, гүйцэтгэх ажлын онцлогтой холбоотой, ажлын заавар, ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа авна

9.3.1 дэх "хөдөлгөөн эхлэхийн өмнө ажлын бүсэд хүн, мал байгаа эсэхийг шалгаж дуут дохио өгнө" гэсэн заалтуудыг тус тус зөрчиж, ажил гүйцэтгэж байгаа талбайн эргэн тойрон орчноо хянаж анхаарал болгоомжтой ажиллаагүй нь осол гарах шалтгаан болсон байна хэмээн дүгнэж Х.Т-ийг гэм буруутгайд тооцсон.



Шүүхээс Х.Т-ийг хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон бөгөөд гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн, хохирлоо нөхөн төлсөн, **"Хувиараа бусдын тээврийн хэрэгсэл барьж орлого олж амьдралаа залгуулдаг. Эхнэр хоёр хүүхэдтэй амьдардаг"** зэрэг хувийн байдлыг харгалзан 01 жил 06 сарын хугацаагаар тэнсэж шийдвэрлэсэн.



# МЭДҮҮШТЭЙ

## Онцлох нь

Ажил олгогч нь:

- Аюулгүй ажиллагааны мэдлэг олгох сургалт явуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэгийг жил бүр шалгах, аюулгүй ажиллагааны зааварчилга өгөх, сургалтад хамрагдаагүй, зааварчилга аваагүй, шалгалт өгөөгүй ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлэхгүй байх;
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтанд хууль тогтоомжийн дагуу нөхөн төлбөр олгох үүрэгтэй.

## Онцлох нь

- Ажилтан нь:
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан байх, хуульд тусгайлан заасан бол шалгалт өгсөн, аюулгүй ажиллагааны зааварчилга авсан байх;
- Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх нөхцөл бий болсон тохиолдолд аюулгүй байдлын дүрэм, журамд заасны дагуу шуурхай арга хэмжээ авах;
- Ажил олгогчийн зүгээс хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэн тавьсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг биелүүлж ажиллах.

## Хууль тогтоомж

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.



## НЭХЭМЖЛЭГЧ ИРГЭН "А"

Амь хохирогч болох "Х" ХХК-иас үйлдвэрлэлийн ослын улмаас нас барсан ажилтны ар гэрт олгох 36 сарын цалинтай тэнцэх хэмжээний нөхөн төлбөр 24174059 төгрөг, оршуулгын тэтгэмж 1000000 төгрөгийг гаргуулж өгөхийг хүссэн байна.

**Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлд** зааснаар Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас нас барсан ажилтны ар гэрт 36, түүнээс дээш сарын цалинтай тэнцэх нөхөн төлбөрийг нэг ба түүнээс дээш удаа олгох заалтын дагуу 36 сарын нөхөн төлбөр 24,174,059 төгрөг төгрөгийг гаргуулах, мөн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2-т Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан бол оршуулгын тэтгэмжийг шимтгэл төлсөн хугацааг харгалзахгүйгээр олгоно гэж заасан байх тул оршуулгын тэтгэмж гаргуулах гэж тайлбарлажээ.

## ХАРИУЦАГЧ "Х" ХХК

Үйлдвэрлэлийн ослын улмаас О ийн амь нас хохирсон гэж үзэх шууд нотлох баримт байхгүй байгаа тул талийгаачийн ар гэрт 36 сарын тэтгэмж гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэх боломжгүй байна.

Золгүй ослын улмаас хүний алтан амь нас хохирсон, ар гэрийн байдалд хүнд гачигдал учирсан, Х ХХК-ийн ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зохих дэмжлэг үзүүлэх зорилгоор, чиг үүрэгтэй ажиллаж ирсэн уламжлалыг дагаж, нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсэг болох 12000000 төгрөгийг нөхөн олгоход татгалзах зүйлгүй



Та энэ тохиолдлыг хэрхэн  
дүгнэж байна вэ?



Шүүх тус иргэний хэргийг хянан хэлэлцээд **Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1, 97.1.2, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасныг баримтлан Х ХХК-аас 12,000,000 төгрөгийг гаргуулан А-д олгож, нэхэмжлэгчийн илүү нэхэмжилсэн 13,174,000 төгрөгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.**

*Дээрх шийдвэр нь 2021 оны шийдвэр учир 1999 оны Хөдөлмөрийн тухай хуулийг баримтлан шийдвэрлэсэн болохыг анхаарна уу.*



# МЭДҮҮШТЭЙ

## Арга хэмжээ

- Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн иргэн, ажилтныг өөрийн зардлаар эмнэлэгт хүргэх, шаардлагатай үзлэг шинжилгээний зардлыг хариуцах, осол, хурц хордлогын хор уршгийг арилгах арга хэмжээг 24 цагийн дотор авна.
- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судалж бүртгэх зардлыг осол гарсан аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.

## Мэдээлэх

Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын тухай мэдээг тогтоосон журмын дагуу аймаг, сум, нийслэл, дүүргийн статистикийн байгууллагад мэдээлнэ.

## Хориглох

Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг нуун дарагдуулахыг хориглоно.



Анхаарал хандуулсанд  
баярлалаа